

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлагад тохирсон хэрэг хянан шийдвэрлэх хялбар журмыг тусгах, тус ажиллагааг аль болох богино хугацаанд, хэргийн оролцогчийг чирэгдүүлэлгүй, хүндрэл багатай явуулахын зэрэгцээ тэдгээрийн эрх ашгийг дордуулахгүй, хэргээ шударгаар шүүлгэх боломжоор хангагдсан байх зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичигт шинээр үүрэг үүсэхгүй бөгөөд процессын журмыг хөнгөвчилж өгснөөр төрд болон иргэнд үүсэх нэмэлт зардал байхгүй гэж хууль санаачлагч үзсэн. Мөн уг хуулийн төслийг www.d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хуулийн төсөлд цахим нотлох баримтыг шүүхийн шатанд үнэлэх асуудлыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд бага үнийн дүнтэй хэргийг нэг удаагийн шүүх хурлаар шийдвэрлэхээр тусгасан нь иргэдэд чирэгдэл үүсэх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн нэг зүйл өөрчлөгдөхөд бусад олон зохицуулалт дагаж хөндөгддөгийг анхаарах шаардлагатай талаар санал хэлсэн.


Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.ЦОГТБААТАР